

Судлагдахууны нэр:Мэдээлэл зүй
Илтгэлийн нэр: Powerpoint програм
ашиглан объектод дуу, хөдөлгөөн
оруулах

Илтгэлийг бичсэн: Тосонцэнгэл сумын ЕБ-ын
нэгдүгээр сургуулийн багш: Ж.Ёндонсамбуу,
Э.Санжаасүрэн, Б.Сэлэнгэ

Ерөнхий танилцуулга

- ✓ Судалгаат хичээлийг явуулсан үндэслэл:

Хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх нь

Судалгааны зорилго:

- ✓ Сурагчдын хэрэгцээ сонирхол амьдралд ойрхон, цаг үетэйгээ холбогдсон, хурал, илтгэл, тайлан тавихад түгээмэл хэрэглэгддэг соёлтой хэрэглээ учраас сэдвээ сонгосон.

- 
- ✓ Хичээлийн бэлтгэл судалгаанд: багш Ж.Ёндонсамбуу, Э.Санжаасүрэн, Ч.Сарантуяа, Э.Даваадэмбэрэл, Т.Хоролмаа, Монгол хэлний багш Ц.Отгонжаргал, Гэрэл Англи хэлний багш З.Мөнхцэнгэл нар хамтран хийсэн.
 - ✓ 2012 оны 12 сарын 15-нд Завхан аймгийн Зүүн бүсийн Жайкагийн сургалтын үеэр судалгаат хичээлийг Тосонцэнгэл сумын ЕБ-ын 1-р сургуулийн 8Б ангид Их-Уул сумын мэдээлэл зүйн багш Ч.Сарантуяа заалаа.



Энэхүү хичээл 4 удаа заагдсан.

✓ 2011 оны 2 сарын 13нд 2-р
сургуулийн багш Ө.Должинжав

✓ 2011 оны 4 сарын 22нд багш
Ж.Ёндонсамбуу


✓ 2012 оны 3 сарын “Жайкагийн
мониторинг”-оор Багш Г.Оюунгэрэл
тус тус заасан.

Хэрхэн сайжруулсан тухай

- ✓ Word- PowerPoint 2 программыг харьцуулах, ач холбогдлыг хэлүүлэх
- ✓ 3 цэсний ач холбогдлыг сайтар ойлгуулах
- ✓ Техник хэрэгслийг сайтар бэлтгэх
- ✓ Даалгаврын Slide – ны тоог тодорхой өгөх
- ✓ Хэрэглэгдэхүүний харагдах байдал тааруу байсан тул хэрэглэглэхүүнийг сайжруулах
- ✓ Хүүхэд бүрийн компьютер ашиглалт харилцан адилгүй тул бие даалтын олон хувилбартай байх хэрэгтэй.

Хичээлийн эхлэл хэсгийн шийдэл

- ✓ Хичээл эхлэхийн өмнө сурагчдыг компьютер дээр хос хосоор нь суулгасан байна.
- ✓ Энэ ангийн сурагчид өмнөх хичээлүүдээр MS Office-ийн Word програм дээр ажиллаж сурсан дадлага туршлагатай.

- 
- ✓ Хичээлийн эхэнд багш PowerPoint програм дээр бэлтгэсэн сэдэлжүүлэлтийг сурагчдад үзүүлнэ (Ая, дуу явж хөдөлгөөнт зургууд дэлгэц дээр орж ирнэ)


Сэдэлжүүлэлт

- ✓ Үүнийг үзсэн сурагчид энэ програмаар юу юу хийж болохыг ойлгож багштай харилцан ярилцаж хичээлийн зорилгоо тодорхойллоо.


Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл


- ✓ Багш зорилгоо тодорхойлсны дараа бэлтгэсэн тараах материалыг сурагчдад өгч хос хосоор бие даалган ажиллуулна.

(ТӨМ нь PowerPoint програм дээр гол гурван цэсийг ашиглан өгөгдсөн даалгаварыг гүйцэтгэхэд чиглэгдэнэ)

- 
- ✓ Шинээр slide нэмэх
 - ✓ Slide-ийг устгах
 - ✓ Хуудасны төлвийг сонгох
 - ✓ Объект оруулах(зураг, янз бүрийн дүрсүүд)
 - ✓ Хөдөлгөөн оруулах
 - ✓ Тоглуулах

TӨM


- 
- Энэ хичээлийн дээрх 6-н алхмыг сурагчид өөрсдөө зааврын дагуу хийж, туршиж, шалгаж үзсэний дараа “Миний эх орон” сэдэвт танилцуулгыг нэг слайданд багтаан хийнэ.

- 
- ✓ Багш сурагч бүрийг чиглүүлэн ажиллав. Сурагчид өгөгдсөн даалгаварыг хос хосоороо сайн хийж, сэтгэл ханамжтай байлаа.
 - ✓ Энэ хичээлийн арга зүйн туршлага нь сурагчдыг компьютер дээр хос хосоор нь ажиллуулах нь өмнөх хичээлүүдээс илүү их үр дүнтэй байгаа нь багаар ажилласан багш нарт харагдаж байна.

Хичээлийн төгсгөл хэсгийн шийдэл


- ✓ ТӨМ-ийн даалгаваруудыг хийж дууссаны дараа багш дурын сурагчдыг босгон Design, Animation, Slide show гэсэн гурван цэсийн үүргийг асуув. Сурагчид дадлага ажлаа сайн хийснээ баталж 3-н цэсний үүргийг сайн тайлбарлаж байв.


- 
- ✓ “Гэр бүл” сэдэвт зургийн цомог хийх дадлага ажлыг гэрийн даалгаварт өглөө. (сурагчид ТӨМ-аа ашиглана)
 - ✓ Сурагчид Insert цэсний shapes-с smile сонгож будалт хийж өөрсдийгөө үнэлснээр хичээл дууссан.

- 
- ✓ Маш сайн ойлгосон бол улаанаар
 - ✓ Хангалттай ойлгосон бол хөхөөр
 - ✓ Хангалтгүй ойлгосон бол шараар тус тус будна.
 - ✓ Ангийн ихэнх сурагчид улаан буюу хөхөөр будсан нь энэ хичээл чанартай болсныг харуулж байна.

Дүгнэлт

- Энэ хичээлийн сэдэлжүүлэлт товч бөгөөд ойлгомжтой, дараа дараагийн үйл ажиллагаатайгаа сайтар холбогдож өгсөн нь энэ хичээлийн бэлтгэл судалгаа чанартай болсныг харуулж байна. Энэ хичээлээр сурагчид илтгэл, тайлан тавих, ая дууны хамт зургийн цомог хийх зэрэгт түгээмэл хэрэглэж болохыг сайтар ойлгосон нь сурагчдыг цааш хөгжихөд нь нэг алхам ахиуллаа.

- 
- Манай багийн гишүүдийн ажигласанаар Мэдээлэл зүйн хичээлд сурагчдыг хосоор ажиллуулах нь илүү үр дүнтэй болохыг энэ хичээлээр ойлгож авсан.
 - *Сайжруулсан хичээлийн хөтөлбөр*



Анхааралаа хандуулсанд
баярлалаа.